

БАТЛАВ.

БАТЛАВ.

ЗАМ,ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
Ж.БАТ-ЭРДЭНЭХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
Ц.НЯМДОРЖ

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагын талаар

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 5.1-д “Бодлогод заасан зорилтыг хэрэгжүүлж, бодит үр дүнд хүрэхийн тулд түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ”, 5.2-д “Төмөр замын салбарт дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, тээвэрлэлтийн үйл ажиллагааны харилцааг хуульчлах замаар төмөр замын тээврийн салбарын эрх зүйн орчинг сайжруулна”, 5.3-д “Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь тусдаа хуулийн этгээд байж болох бөгөөд өмчийн олон төрөл, хэлбэрийн тээвэрлэгч бий болох орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 72 дахь заалтад Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газар санаачлан боловсруулахаар заасан.

Мөн 2007 оноос хойшх хугацаанд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай, Барилгын тухай, Зөрчлийн тухай, Хууль тогтоомжийн тухай болон Захиргааны ерөнхий хууль шинээр батлагдан гарсантай уялдуулан төмөр замын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага үүссэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 115 дугаар тушаалаар байгуулсан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт, Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу 2007 онд батлагдан мөрдөгдөж буй Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авах явцад төмөр замын тээврийн салбарын 1100 гаруй ажилтан, албан хаагчид уг хуулийг “зорилтоо биелүүлж, үүргээ гүйцэтгэж байгаа хэдий ч одоогийн нөхцөл байдалд салбарт хуулийн зохицуулалт шаардсан, тулгамдаж буй олон асуудал байна” гэж үзсэн, мөн Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүнд “Төмөр замын тээврийн тухай хууль”-ийг шинэчлэн найруулах шаардлагатай гэсэн дүгнэлт (зөвлөмж) гарсан.

Мөн Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн 2017 оны “Төмөр замын тээврийн эрх зүйн орчин, хөгжлийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурлаас төмөр замын тээврийн эрх зүйн орчинг сайжруулах зөвлөмж гарсан.

1.2. Практик шаардлага

Төмөр замын тээврийн тухай хууль мөрдөгдөж эхэлснээс хойшхи 10 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг, нийгэмд гарч буй өөрчлөлт нь төмөр замын тээврийн эрх зүйн орчныг сайжруулах дараах шаардлагыг бий болгож байна.

1. Төмөр замын тээврийн салбарт 2007 оны байдлаар суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч 1 (“УБТЗ” ХНН), тээвэр зуучийн байгууллага 80 орчим байсан бол өдгөө суурь бүтэц эзэмшигч 3, тээвэрлэгч 3, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 34, дагнасан болон салбар зам, талбай эзэмшигч 297, тээвэр зуучийн байгууллага 213 буюу нийт байгууллагын тоо 550 орчим болж өргөжсөнтэй холбоотой шинээр бий болж буй нөхцөл байдлыг харгалзан, хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, төрийн зохицуулалтын хэм хэмжээг шинэчлэн тогтоох;

2. Төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явцад тулгарсан эрх зүйн зохицуулалтгүй асуудлуудыг шийдвэрлэх;

3. Бодлого, төлөвлөлттэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулах;
4. Хуулийн нэр томъёог шинэчлэх, сайжруулах;
5. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг аюулгүй, чанартай, хүртээмжтэй үйлчилгээгээр хангах, үндэсний төмөр замын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, салбарын тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний техникийн шаардлага, стандартчилал, тохирлын үнэлгээ, хяналт бүхий техникийн зохицуулалтын болон салбарын мэргэжилтний тасралтгүй сургалтын тогтолцоог бий болгох;
6. Төмөр замын салбарын хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэхдээ эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоо, судлаач, хэрэглэгчийн оролцоог хангах, олон улсын шинжлэх ухаан, технологийн үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, бодлогын болон технологийн чиглэлээр дагнасан судалгааны институцийг бий болгох, үйлдвэрийн дэргэдэх болон хараат бус лаборатори, туршилт, сорилтын баазыг бэхжүүлэх;
7. Гадаадын “шилдэг технологи”-ийг сонгон нэвтрүүлж, ашиглахыг дэмжих, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр мэргэшсэн судлаач бэлтгэхэд олон улсын тусламж, дэмжлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээг идэвхжүүлж, үндэсний (хамтарсан) үйлдвэр байгуулах, тусгай зөвшөөрөл, ноу-хау, технологи, тоног төхөөрөмж худалдан авах хэлбэрээр өндөр болон тэргүүний технологийг нутагшуулах арга механизмыг бүрдүүлэх;
8. Салбарт үр ашигтай хэмнэлтийн тогтолцоог бүрдүүлэх;
9. Төмөр замын тээврийн үндсэн сүлжээг улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
10. Төмөр замын салбар дахь эдийн засгийн зохицуулалтыг боловсронгуй болгох;
11. Тээвэрлэлтийн эрх зүйн зохицуулалтыг хуульчлах;
12. Төмөр замын тээврийн үндсэн зарчмыг хангах үүднээс салбарын үйл ажиллагааг улс төрийн сөрөг нөлөөллөөс ангид байлгах;
13. Төмөр замын дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэлт, хүчин чадлыг тооцоолсон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй байхыг хуульчлах;
14. Тээвэр зуучийн үйл ажиллагаанд зах зээлийн шударга өрсөлдөөнийг дэмжих, хүнд суртлыг арилгахад чиглэсэн зохицуулалтыг бий болгох;
15. Хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийг хамгаалах, үйлдвэрлэлийг өргөтгөх, шинэчлэхтэй холбоотойгоор төмөр замын аюултай бүс, зурвас газар, аюулгүйн бүсийн халдашгүй байдлыг хангуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

Төмөр замын тээврийн тухай хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад өөрчлөлт орсон тул дээр дурьдсан үндэслэл, практик шаардлагатай уялдуулан уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжсэн, олон улсын тэргүүлэх түвшинд хүрсэн, хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээг аюулгүй, чанартай, хүртээмжтэй үйлчилгээгээр хангасан, үр ашигтай тогтолцоог бэхжүүлэх зарчмыг баримтлан төмөр замын объектыг барих, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг уг хуулиар зохицуулахаар хуулийн төслийг боловсруулна.

Өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагааг хамрахаар хуулийн төсөлд тусгана.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дараах бүтэцтэй байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, нэр томъёоны тодорхойлолт, төмөр замын тээврийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгана.

Хоёрдугаар бүлэгт Төмөр замын дэд бүтцийн ангилал, төрөл, зэрэглэл, өмчлөл, эзэмшил, ашиглалт, засвар, үйлчилгээ, шинэчлэн сайжруулалт, зурвас газар, аюулгүйн болон аюултай бүс зэрэгтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Гуравдугаар бүлэгт Хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл, эзэмшил, ашиглалт, үйлдвэрлэл, засвар, үйлчилгээ, шинэчлэн сайжруулалт зэрэгтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт Иргэний хуулиар зохицуулагдаагүй ачаа болон зорчигч тээвэрлэлттэй холбоотой зарим суурь харилцааг зохицуулахаар тусгана.

Тавдугаар бүлэгт Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангасан төмөр замын тээврийн үр ашигтай тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн эдийн засгийн зохицуулалттай холбоотой асуудлыг тусгана.

Зургадугаар бүлэгт Төмөр замын тээврийн салбарын стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлтэй холбоотой асуудлыг тусгана.

Долдугаар бүлэгт Төмөр замын тээврийн салбарын судалгаа шинжилгээний тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Наймдугаар бүлэгт Төмөр замын ажилтантай холбоотой зохицуулалтыг тусгана.

Ес дүгээр бүлэгт Төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой зохицуулалтыг тусгана.

Аравдугаар бүлэгт Төмөр замын тээвэр дэх төрийн чиг үүргийн хуваарилалтын талаар тусгана.

Арваннэг дүгээр бүлэгт Салбарын бусад зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт дараах үр нөлөө гарна.

Нэг. Нэр томъёонд шинээр оноолт хийснээр тэдгээрийн ойлголтыг нэг мөр болгох, хуулийн үзэл санааг зөв илэрхийлэх ач холбогдолтой. Мөн төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг шинэчлэн тогтоосноор хууль хэрэгжүүлэхэд баримтлах хууль зүйн үндсэн чиглэмж, ухагдахуун боловсронгуй болно.

Хоёр. Төмөр замын ангилал, төрөл, өмчлөл, эзэмшил, ашиглалт, засвар, үйлчилгээ, шинэчлэн сайжруулалт, зурвас газар, аюулгүйн болон аюултай бүс зэрэгтэй холбоотой зохицуулалтыг хуулинд тусгаснаар төмөр замын тээврийн аюулгүй, үр ашигтай байдлыг сайжруулах эрх зүйн тогтолцоо боловсронгуй болох суурь тавигдана.

Гурав. Хөдлөх бүрэлдэхүүнийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, техникийн зохицуулалт бүхий тогтолцоог бий болгосноор тээврийн болон үйлдвэрлэлийн аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх, техникийн бэлэн байдал, ашиглалтыг сайжруулах, үндэсний завсар, үйдвэрлэлийн баазыг хөгжүүлэх эрх зүйн орчин нөхцөл сайжирна.

Дөрөв. Хуулиас дээгүүр болзол шаардлагыг дүрэм, журмаар тогтоохоос татгалзаж, Иргэний хуулиар зохицуулагдаагүй ачаа болон зорчигч тээвэрлэлттэй холбоотой зарим суурь харилцааг хуулийн хүрээнд илүү тодорхой, нийтэд ойлгомжтой байдлаар зохицуулснаар иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх төмөр замын тээвэрлэлттэй холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалт сайжирна.

Тав. Төмөр замын тээврийн салбар дахь эдийн засгийн зохицуулалтын асуудлыг хуульчилснаар тээврийн хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах, тээврийн зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн техник, эдийн засгийн, түүний дотор татвар, үнийн зохицуулалт, хэмнэлт, инноваци, нөөцийн удирдлага, хөрөнгө оруулалт, орлогын дахин хуваарилалт зэрэгтэй холбоотой салбарын эрх зүйн зохицуулалт бий болно.

Үүний үр дүнд тээврийн бодит өртөг бүхий, ашгийн зохих түвшинг хангасан үнэ тарифийн уян хатан бодлого хэрэгжүүлэх, улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээний өртөгт тээврийн зардлын хувийг бууруулах, үндэсний төмөр замын олон улс дахь өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тээвэрлэлтийг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд үе шаттай шилжүүлэх, тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэгт эерэг нөлөө үзүүлнэ.

Зургаа. Төмөр замын тээврийн салбар дахь техникийн зохицуулалтын асуудлыг хуульчилснаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон орчны аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой төмөр замын дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүнд тавигдах техникийн шаардлага, стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэл бүхий тогтолцоог бий болгож, хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, үндэсний төмөр замын олон улс дахь өрсөлдөх

чадварыг нэмэгдүүлэх, салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг эерэг нөлөө үзүүлнэ.

Долоо. Төмөр замын тээврийн салбарын судалгаа шинжилгээний тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгаснаар “шинжлэх ухаан-боловсролын болон шинжлэх ухаан- үйлдвэрлэл- аж ахуй”-н нөөц бололцоог дайчлах, уялдааг тэнцвэртэй хангах, олон улс болон бүс нутгийн шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, эрдэм шинжилгээний байгууллага, үйлдвэрийн дэргэдэх болон хараат бус лаборатори, туршилт, сорилтын баазыг бэхжүүлэх, мэргэшсэн эрдэмтэн, судлаачдыг тоо, чанарын хувьд зохистой түвшинд хүргэх, улмаар салбарт судалгаа, шинжилгээнд суурилсан бодлого, үйл ажиллагааг явуулах нөхцөл бүрдэнэ.

Найм. Төрийн байгууллага, албан тушаалтны оролцоо, чиг үүргийг журамласнаар тэдгээрийн чиг үүргийн давхцал, хийдэл багасаж, харилцан уялдаа, хуваарилалт бүхий салбарын төрийн зохицуулалтын эрх зүйн орчин сайжирна.

Ес. Төмөр замын салбарын ажилтанд тавигдах шаардлага, үйл ажиллагааны хүрээ, мэргэжилтний тасралтгүй сургалтын тогтолцоо, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан зэрэгтэй холбоотой харилцаа хуульчлагдана.

Арав. Төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой барилгын ажлын төрөл, барилга байгууламжийн ангилал, үйл ажиллагааны зарчим, зураг төсөл, материал, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, барилга байгууламж, барилгын ажлын талбайд тавигдах шаардлага, төмөр замын барилгын ажлын тусгай зөвшөөрөл, хяналт, зураг төслийн магадлал зэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалт бий болно.

Арван нэг. Төмөр замын салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгаснаар олон улсын тээврийн тогтолцоонд Монгол Улс нэгдмэл байр сууринаас оролцох, улмаар байр сууриа бэхжүүлэх, олон улсын тээврийн эрх зүйн болон техникийн нийцлийг хангуулах, монголын нутгаар дамжин өнгөрөх тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, үндэсний худалдаа, тээврийг дэмжих, олон улсын тэргүүн туршлага, дэвшилтэт техник, технологийг сонгон нутагшуулах зэрэг боломж нэмэгдэнэ.

Төмөр замын тээврийн салбар дахь даатгалын төрөл хэлбэрийг шинэчлэн тогтооно.

Салбарын хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт зэргийг боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангахтай холбоотой зохицуулалтыг бий болгоно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Иргэний хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай, Засгийн агентлагийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль зэрэг хүчин төгөлдөр үйлчилж буй хуультай нийцүүлэн боловруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Газрын тухай хууль, Авто замын тухай хууль, Агаарын тухай хууль, Барилгын тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Дайны байдлын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрлийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Ойн тухай хууль, Тагнуулын байгууллагын тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулна.